



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/НН

Мандалговь

Г

Хөрөнгө гаргах тухай

Г

Монгол Улсын Засаг зариргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрдэнэдалай, Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдын нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт хонины "Цэцэг" өвчиний үед хорио цээрийн дэглэм тогтоож ажиллахад зарцуулсан зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Уг арга хэмжээнд шаардагдах 7,974,008 / долоон сая есөн зуун далан дөрвөн мянга найман төгрөг/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000299